

## СПОРТЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНЦЛОГ, ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Б.Наранбаатар\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

**Түлхүүр үг:** спортын сэтгүүл зүй, спорт, Олимпын наадам, төрөлжсөн хэвлэл мэдээлэл, спортын сэтгүүлч, спортын сэтгүүл зүйн үүрэг, үр нөлөө

**С**этгүүл зүйн салбар чиглэлийг ангилах нэг шалгуур нь сэдэв байдаг. Эдийн засгийн, экологийн, спортын сэтгүүл зүй гэх зэргээр төрөлжсөн чиглэлүүд нь өөр өөрийн өвөрмөц онцлог, хөгжлийн хандлага, үр нөлөөтэй байхаас гадна сэтгүүлчийн үйл ажиллагаа мэргэшин нарийвчлагдах үндэс болдог.

Спорт нь хүн төрөлхтний үнэт өв, эв нэгдлийн болон шударга өрсөлдөөний талбар байхаас гадна олон нийтийн анхаарал, сонирхлыг татдаг, ухамсар төлөвшилд нөлөөлдөг мэдээлэл харилцааны чухал төрөл юм. Иймд даяар болон үндэсний түвшинд ОНМХ-үүд спортын үйл явдал, мэдээлэлд өндөр ач холбогдол өгч нийтлэл, нэвтрүүлгийн бодлогодоо зайлшгүй тусгаж иржээ.

Түүхийг сөхвөл XIX зууныг хүртэл спортын амьдрал нь нийгмийн харилцааны бие даасан хэлбэр болж төлөвшөөгүй байсан юм. Улс орнуудад үндэсний шинж чанартай спортын уралдаан тэмцээнүүд болдог ч тамирчид, сонирхогчдын хүрээнд өнгөрч, мэдээлэл нь ам дамжих хэлбэр түгдэг байв. Чухам XIX зууны эхнээс зарим спортын төрлүүдийн хөгжил дэвшилд

анхаардаг тогтолцоо үүсэж эхэлснээр сонин сэтгүүлийн нүүрт спортын мэдээ, үйл явдал гарч эхэлжээ. Анх 1893 онд АНУ-ын нэрт сэтгүүлч Жозеф Пулитцер өөрийн “New York World” сонины редакцияд спортын мэдээний албыг байгуулж, спорт мэдээний булантай болж байв.

1894 онд Францын гүн Пьер де Кубертен эртний Грекийн Олимпын наадмыг сэргээх санал гаргаснаар 1896 онд Афин хотноо орчин үеийн анхны Олимп зохион байгуулах шийдвэр гарч, Олон улсын Олимпын хороо байгуулагджээ<sup>1</sup>. Энэ үйл явдал нь олон улс оронд спортын сэдэв, үйл явдал хэвлэл мэдээллийн бодлогод чухал байр суурь эзлэх болжээ. Ингэснээр спортын сэтгүүл зүй бие даан хөгжих, спортын чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчид төрөн гарах сэдэл үүссэн аж.

Өдгөө спортын сэтгүүл зүй нь хамгийн олон хүний анхаарал, сонирхол татдаг, амжилт, гавьяа нь нийтээр хүлээн зөвшөөрөгддөг, өрсөлдөөн ихтэй, мэргэжлийн спортуудад түшиглэн хөгжиж байна. Ялангуяа, өвөл, зуны Олимпын наадмууд, хөл бөмбөг, хөнгөн атлетик, хоккей гэх мэт спортын түгээмэл төрлүүдийн ДАШТ, мэргэжлийн лигийн АШТ зэрэг нь спортын сэтгүүл зүйн чиг хандлагыг тодорхойлж байна. Мөн тухайн улс оронд ямар спорт түлхүү хөгжсөн, үндэсний спортын ямар төрлүүд уламжлагдаж ирсэн нь мэргэшсэн мэдээллийн сувгууд,

сэтгүүлчдийн үйл ажиллагааны өнгө төрх, онцлогийг бүрдүүлдэг. Тухайлбал, Монгол Улсад үндэсний спортын төрлүүд чухал байр суурьтайгаас гадна Олимпын амжилт гаргаж ирсэн ТОП-4 төрөл болох чөлөөт бөх, жүдо, бокс, байт сурын тэмцээнүүдэд өндөр ач холбогдол өгдөг. Мөн үүний зэрэгцээ мэргэжлийн Лигүүдийн сагсан бөмбөг, хөл бөмбөг, тулааны спорт, хүнд хөнгөн атлетикийн тэмцээн, үйл явдал, тамирчид, тэдний түүх монгол үзэгч, уншигчийн онцгой анхааралд байдаг.

1908 оны Лондонгийн Олимпын наадам спортын сэтгүүл зүйн түүхэнд онцгой үүрэгтэй тэмдэглэгдэн үлдсэн юм. Сонгодог сэтгүүл зүйн гал голомт болсон Англид бүх л сонин сэтгүүл энэ үйл явдалд онцгой анхаарч, аль л шилдэг нийтлэлч, зохиолчдоо Олимпын наадмын сурвалжилга хийлгэхээр дайчилж байв. “Daily Mail” сонинд ажиллаж байсан алдарт зохиолч, сэр Артур Конан Дойл холын зайн марафоныг үзэж, сурвалжилсан нь хожмоо, тухайн үеийн спортын сэтгүүл зүйн түүхэнд жишиг болж үлдсэн юм. Энэ Олимпын 42 км-ийн марафонд оролцсон Италийн тамирчин Дорандо Пьетри бусдаас хол тасархай түрүүлж, цэнгэлдэх хүрээлэнд орж ирсэн боловч, хэт ядарсны улмаас барианд орох сүүлийн 200 метр зайд таван удаа бүдэрч унан, шүүгчийн дэмжлэгтэй босож, тэмцсээр түрүүлсэн юм. Гэвч хоёрдугаар байрт орсон АНУ-ын тамирчин Жон Хейсийн багийнхан “Пьетри барианд орохдоо бусдын дэмжлэг авсан” хэмээн гомдол гаргаснаар Италийн тамирчин алтан медалиа хураалгасан юм. Артур Конан Дойл энэ үйл явдлыг гайхалтай зураглан бичсэнээс гадна Олимпын дараа Дорандо Пьетриг дэмжих олон нийтийн аян өрнүүлж, тусгай мөнгө цом бүтээлгэс-

нийг нь Хатан хаан Александра гардуулж байв<sup>2</sup>.

Өдгөө зөвхөн спортын сэдэв чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улс орон, тив дэлхийд нэртэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон болсон бөгөөд АНУ-ын “Sports Illustrated”, “Sporting News” сэтгүүлүүд, Италийн La Gazzetta Dello Sport, Испанийн Marca, Францын L'Equipe сонинууд, олон улсын сүлжээ телевизийн сувгууд болох ESPN, Sky Sports, Eurosport зэргийг дурдаж болох юм. Мөн спортын аль нэг төрлөөр мэргэшин, олон нийтийн мэдээллийн хэрэгцээг хангадаг, олон талт үйлчилгээтэй интернэт эх сурвалжууд хүчтэй хөгжиж байгааг онцлох нь зүйтэй.

**Я**вцуу утгаар нь тодорхойлбол, спортын сэтгүүл зүй гэдэг нь спортын сэдэв, үйл явдал, тэмцээн, тоглолтын үр дүнгийн талаарх мэдээллийн хүлээн авагчдад хүргэж буй ОНМХ-ийн үйл ажиллагааны цогц юм.

Орчин үед аливаа спортыг зөвхөн уралдаант, хөгжөөн цэнгээнт үйл гэдгээр тодорхойлох нь дутагдалтай юм. Нийгмийн аливаа үйл, үзэгдэл нь спорт гэж нэрлэгдэхийн тулд наад зах нь дараах гурван шаардлагад нийцэх ёстой. Үүнд: 1. Биеийн болон оюуны үйлийн төрлөөр боломжит хамгийн өндөр үзүүлэлтэд хүрэх тэмүүлэл, 2. Тодорхой зохион байгуулалттайгаар өрнөдөг тэмцээн, тэдгээрээс уялдаа бүхий нийгмийн харилцаа үүсэх, 3. Эдгээр тэмцээний үр дүнг ач холбогдол бүхий хэмээн нийгэмд хүлээн зөвшөөрдөг байх.

Аливаа спорт нь бизнес, эдийн засгийн хүчин зүйлтэй нягт холбоотой байдаг. Уралдаан тэмцээний гол үр дүн, зорилго нь тамирчны хувьд ч, зохион байгуулагчдын хувьд ч ашиг орлого юм.

Спорт нь олон нийтийг хамгийн ихээр татаж чаддаг, гоо зүйн үзвэр болдог үндсэн шалтгаан нь ихэнх төрлүүд хүний бие, оюун, хөдөлгөөний гоо сайхныг харуулдагт оршино.

Спортын сэтгүүл зүйг *мэдээллийн, зохион байгуулалтын, удирдлагын, ухуулгын, боловсрол, хүмүүжлийн, сурталчилгааны үүрэг* гүйцэтгэдэг гэж үздэг<sup>3</sup>.

*Мэдээллийн үүрэг:* Сэтгүүл зүйн нэг үндсэн чиглэл болохын хувьд мэдээллийн үүрэг нь хамгийн түгээмэл, суурь шинжийг агуулдаг. Спортын ертөнцөд өрнөж буй тэмцээн уралдаан, тэдгээрийг тойрсон үйл явдлын тухай мэдээллийн хэрэглэгчдэд хүргэх нь нэн тэргүүний зорилт юм.

*Зохион байгуулалтын үүрэг* нь спортын арга хэмжээний бэлтгэл, үйл явц, ач холбогдолд олон нийтийн анхаарлыг татаж байдгаар илэрнэ.

*Удирдлагын үүрэг* нь спортын мэдээллийн хэрэглэгчид, спортын салбарын бүтэц, нэгжүүдийн үйл ажиллагаанд нөлөөлж байдаг чадамжид оршиж байна.

Спортын тухай мэдлэгийг түгээхийн зэрэгцээ аливаа спорт, бие тамирт олон нийтийн сонирхлыг өдөөж, санаа бодлыг төлөвшүүлж, аливаа спортын төрөл, эсвэл хэн нэг тамирчны имижийг бүрдүүлж буй нь *ухуулгын үүрэг* юм.

“Яагаад биеийн тамираар хичээллэх ёстой вэ?”, “Хэрхэн спортоор хичээллэж, ямар үр дүнд хүрэх вэ?”

гэсэн асуултууд спортын үнэт зүйлийг илтгэж, тэгш бие бялдар, эрүүл мэндэд тэмүүлэх хүний хэрэгцээнд суурилсан үйл ажиллагаа нь *боловсрол, хүмүүжлийн үүргийг* тодорхойлно.

*Сурталчилгааны үүрэг:* Спортын төрөл, тэмцээн, уралдаан нь хэдий чинээ их мэдээлэл түгээнэ, төдий чинээ ашиг орлого олох боломж бүрддэг. Иймд нэр хүндтэй спорт, тэмцээн наадмуудын үйл явц нь арилжаа, зар сурталчилгаа, бизнесийн томоохон талбар билээ. Олон улсын теле биржүүд дээр хамгийн борлуулалт сайтай, нэр хүндтэй, үнэтэй, мөн ашиг орлоготой контентууд спортынх байдаг нь ч үүнтэй холбоотой.

Өдгөө спортын сэтгүүл зүй нь хэвлэл мэдээллийн орон зай, тогтолцоонд томоохон байр суурь эзлээд зогсохгүй, мультимедиа, интерактив шинжтэй бүх л шинэ технологийг нэн тэргүүнд ашиглан, сэтгүүл зүйд нутагшуулдаг үр нөлөөтэй салбар болжээ.

Спортын сэтгүүл зүйн нийтлэл, нэвтрүүлгийн төрөл зүйлийн тухайд сэтгүүл зүйн ерөнхий хэв шинж, шаардлагад багтаж явдаг боловч онцгой нэр хүндтэй, нөлөөтэй, өвөрмөц шинжтэй төрлүүд бий. Жишээлбэл, олны анхаарал татсан спортын тэмцээний шууд дамжуулалт, тайлбарлагч-сэтгүүлчийн ажил нь сэтгүүл зүйн өөр ямар ч сэдэв чиглэлд давтагдашгүй юм.

Мэдээллийн, задлан шинжилсэн, нийтлэл уран сайхны бүх л төрлөөр

«  
**Спортын сэтгүүл зүйн нийтлэл, нэвтрүүлгийн төрөл зүйлийн тухайд сэтгүүл зүйн ерөнхий хэв шинж, шаардлагад багтаж явдаг боловч онцгой нэр хүндтэй, нөлөөтэй, өвөрмөц шинжтэй төрлүүд бий. Жишээлбэл, олны анхаарал татсан спортын тэмцээний шууд дамжуулалт, тайлбарлагч-сэтгүүлчийн ажил нь сэтгүүл зүйн өөр ямар ч сэдэв чиглэлд давтагдашгүй юм**

»

спортын мэдээллийг бэлтгэж болдог, олон нийтэд хүрдэг бөгөөд тухайн мэдээллийн хэрэгслийн төрөл /ТВ, радио, сонин, сэтгүүл, портал-сайт, мэдээллийн агентлаг/, нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод эзлэх хувь хэмжээнээс хэр цар хүрээнд спортын үйл явдлыг бэлтгэх төрөл зүйлийн тоо хамаарна.

Монгол Улсад бие тамир, спортын сэдэв ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод тодорхой орон зайг эзэлсээр ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд спортоор, аль нэг төрлөөр мэргэшсэн мэдээллийн сувгууд бий болж, олон улсын спорт мэдээллийн салбарын интеграцид нэвтрэн, зохиогчийн эрх, олон улсын стандартыг баримталсан контент хэрэглэгчдэд хүргэх болсон нь том дэвшил юм.

Монголд төрөлжсөн спорт мэдээллийн ОНМХ-ын анхдагч нь 1960-д онд гарч байсан “Спортын мэдээ” сонин бөгөөд араасаа олон мэдээллийн суваг дагуулжээ. “Таван цагариг”, “Бөх”, “Спортын өнгө” сонинууд, “SPS” олон сувагт ТВ, “Sport Vox”, “Одод”, “Сүлд” зэрэг телевизийн төрөлжсөн сувгуудаас гадна МҮОНТ, ТВ9, ETV, C1, NTV гэх мэт сувгууд өөр өөрийн өнгө аяс, онцлог бүхий нэвтрүүлгийн бодлогоор спортын төрлүүд, үйл явдлыг олон нийтэд хүргэж байна. Үүний зэрэгцээ спорт мэдээллийн портал сайт, нийгмийн сүлжээний сувгууд эрчтэй хөгжиж байна.

Монголын үзэгч, спорт дэмжигчид өдгөө Олимпын наадам, томоохон ДАШТ, чухал тэмцээн, тоглолтыг шууд үзэх, мэдрэх боломжтой, энэ чиглэлийн мэдээллийн урсгал хангалттай сайн байгаа нь техник, мэдээллийн технологийн хөгжлийн үр дүн мөн боловч спортын сэтгүүлчид, төрөлжсөн спор-

тын ОНМХ-үүдийн үүрэг, оролцоо нэн их юм.

Манай сэтгүүл зүйн салбараас магадгүй мэдээллийн даяаршил, интеграцид хамгийн сайн нэвтэрсэн, өнөө цагийн хэрэглэгчийн шаардлага, сонирхолд нийцэж яваа тэргүүлэх чиглэл спортын сэтгүүл зүй юм.

**С**портын сэтгүүл зүйн хөгжил нь олон улсын жишгээс хамааран хөгждөг боловч үндэсний спортын мэдээлэл, ёс уламжлал, тэдгээрийг хүргэдэг арга барил чухал нөлөөтэй. Ялангуяа, Монгол Улсад эрийн гурван наадам, түүний үйл явдал, “баатруудыг” олон нийтэд таниулах, сурвалжлах арга барилд монгол үндэстний онцлог, уламжлал нэвт шингэсэн, өвөрмөц байдаг. Тухайлбал, спортын тэмцээний шууд дамжуулалт, тайлбарлагчид тавигддаг олон улсын стандарт, монгол үндэсний бөхийн барилдаанд нийцэхгүй зүйл олонтой.

Спортын сэтгүүлч: Сэтгүүлчийн мэргэшлийн нэг төрөл болох яах аргагүй спорт. Өөрийн дур сонирхол, бага залуудаа хичээллэж байсан спортын төрөл, хоббиндоо хөтлөгдөн сэтгүүлч хүн энэ салбарт орох нь элбэг. Мөн их, дээд сургуулиудад спортын сэтгүүл зүйгээр дагнан мэргэшүүлдэг тохиолдол ч бий. Үүнээс гадна мэргэжлийн тамирчин, дасгалжуулагч, шүүгч байсан хүн спортоо орхисны дараа спортын сэтгүүлч, тайлбарлагч болж алдаршсан тохиолдол цөөнгүй.

Нэн тэргүүнд спортын сэтгүүлч нь дараах үндсэн ажил, үүрэг гүйцэтгэдэг:

- Спортын үйл явдлын мэдээлэл хайх, дүн шинжилгээ хийх, үнэлэн эрэмбэлэх
- Спортын салбарын хүмүүсээс ярилцлага авах
- Энэ сэдэв, чиглэлээр нийтлэл, нэвтрүүлэг, мэдээллийн хөтөлбөр бэлтгэх

- Тэмцээн уралдааны үеэр шууд нэвтрүүлгийг тайлбарлах
- Спортын уралдаан тэмцээний үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх, эсвэл таамаг дэвшүүлэх.
- Спортын түүх, статистик баримтыг судлан, сэтгүүл зүйн контентынхоо үнэ цэн, ач холбогдол, үр нөлөөг дээшлүүлэх гэх мэт.

Сэтгүүл зүйн бусад салбарынхнаас спортын сэтгүүлчдийн хувьд ялгардаг онцлог, давуу тал олон. Тухайлбал, нийгэм-улс төрийн “бараан” сэдвүүдээс хол, ихэвчлэн баяр бахдал, амжилт, ялалтын тухай, түүнд тэмүүлсэн хөгжөөн дэмжигчийн сэтгэл зүйд үйлчилдэг учир, магадгүй хамгийн эерэг сэтгүүл зүйн чиглэл юм. Мөн спортын сэтгүүлч нь тухайн спортын эксперт, шинжээчийн хувиар өөрийн сэтгэл хөдлөл, таамаг, дүгнэлтийг чөлөөтэй илэрхийлж болдог онцлогтой. Сайн мэргэжилтэн гэдгээ харуулж чадвал сэтгүүлч спортын хөгжөөн дэмжигчид, тамирчид, баг хамт олон, шүүгч дасгалжуулагч, спортын лиг, хорооныхны дунд хурдан хугацаанд нэрд гарч хүлээн зөвшөөрөгддөг.

Энэ салбарт шуурхай байдал хамгаас чухал. Сэтгүүлч төдийгүй, спортын мэдээлэл хүргэдэг сувгууд бусдаас нэг хормын өмнө ч атугай тэмцээний үр дүнг хүргэхийн төлөөх өрсөлдөөн улам хурц болж байна. Тэр ч бүү хэл, хиймэл оюун ухааныг бусдаас түрүүлэн нэвтрүүлсэн, хөгжүүлж буй талбар нь спорт болж байна. 2012 оны Лондоны, 2016 оны Рио де Жанейрогийн Олимпоос эхлэн дэлхийн тэргүүлэгч мэдээллийн агентлагууд тэмцээний үр дүнг мэдээлэх, спортын статистик мэдээллийг шууд нэвтрүүлэгт ашиглах зэрэг ажилд хиймэл оюун ухааны программчлалыг

амжилттай хэрэглэсэн нь өдгөө улам өргөжиж хөгжиж байна.

Спортын чухал уралдаан тэмцээн ихэвчлэн амралтын өдөр, эсвэл ажлын бус цагаар болдог, маш их мэдээллийн өгөгдөл, түүх мэдэж байх, оновчтой ашиглах шаардлага тулгардаг зэрэг нь спортын сэтгүүлчээс хувийн зохион байгуулалт, ур чадварын бэлтгэл, ажлын төлөөх сэтгэл, зүтгэлийг өндөр түвшинд шаардаж байдаг.

Орчин үед спорт нь зугаа цэнгэл, сонирхолтой үзвэр, нөлөө бүхий медиа контент байгаад зогсохгүй, улс орны имиж тодорхойлох хүчин зүйлсийн нэг, нийгэм улс төрийн чухал үзэгдэл, эв нэгдэл, үндэсний ухамсрыг бүрдүүлэгч хэсэг болсныг дуу нэгтэй хүлээн зөвшөөрдөг болжээ. Алдар гавьяатай тамирчид нь ямагт хэвлэлийн “баатар” байж, нийгмийн сэтгэл зүй, реклам сурталчилгааны талбарт нөлөө бүхий эрхмүүд болж, олон нийтийн дунд үлгэр дуурайлал авах манлайлагч нар байдаг. Энэ бүхний уг үндэс, учир шалтгаан нь спортын сэтгүүл зүй билээ.

### Эшлэл

- <sup>1</sup> Любимов А. Олимпийские Игры, МОК и СМИ//Медиатренды. №6. МГУ, Москва, 2012. стр 4.
- <sup>2</sup> Шарков Ф.И., Силкин В.В. 2018. Спортивная журналистика в сфере современной медиакоммуникаций// Communivoly. Vol.6. Москва. стр 64
- <sup>3</sup> Алексеев К, Ильченко С. 2016. Основы спортивной журналистики. Санкт-Петербург. Стр 23.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль. М. 2007. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
2. Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.
3. Ганцэцэг С. 2010. Спортын сэтгүүл зүй. УБ.

4. Алексеев К. Ильченко С. 2016. Основы спортивной журналистики. Санкт-Петербург.

**Резюме**

Статья посвящается теме о спортивной журналистике как о неотъемлемой части в сфере медиакоммуникаций и деятельности СМИ в Монголии. Автор затрагивает

вопросы об истории и формировании спортивной журналистики, её социальных функциях, приводит примеры и дает выводы деятельности спортивных журналистов и спортивных СМИ в Монголии.